



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/165

Улаанбаатар хот

Газар эзэмших эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 74 дүгээр тогтоол, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших хүсэлт гаргасан 5 (тав) аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг олгож, хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших эрх олгогдсон аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, Улсын бүртгэлд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, газрыг зориулалтын дагуу зөв зохистой эзэмшихийг холбогдох байгууллагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 09 сарын 10 ны өдрийн АХЖ дугаар
захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ ОЛГОЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

№	Газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын		Газрын				Ашиглалтын төрөл
	Оноосон нэр	Регистрийн дугаар	Байршил	Зориулалт	Хэмжээ (м ² -аар)	Хугацаа (жил)	
1	Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс	9167331	1-р хороо, ногооны талбайн хойд талд	Нэгдсэн сургалтын төв	200000	15	Эзэмших
2	Нийслэлийн ерөнхий боловсролын Хангай сургууль	6115993	1-р хороо, Өндөртөлгой	Сургууль	7226	15	Эзэмших
3	"Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж" ААТҮГ	6813038	1-р хороо, ногооны талбай	Мод үржүүлэг	3585	15	Эзэмших
4	Нийслэлийн Багахангай дүүргийн Боловсролын хэлтэс	8301476	1-р хороо, Өндөртөлгой	Цэцэрлэг	6164	15	Эзэмших
5	Багахангай, Налайх дүүргийн шүүхийн тамгын газар	5792738	2-р хороо, Замчин	Албан контор	1500	15	Эзэмших